



**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН  
БИЕЙН ТАМИР, СПОРТ ХОРООНЫ  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/65

Улаанбаатар хот

**Иргэдийн спортын XI наадмыг  
Баянзүрх дүүрэгт зохион байгуулж, шигшээ  
тэмцээнд оролцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, "Биеийн тамир, спортын тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалт, Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/650, 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/704 захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1. "Иргэдийн спортын XI наадам"-ыг Баянзүрх дүүргийн хэмжээнд нэгдсэн зааврын дагуу 2023 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс 11 дугаар сарын 05-ны өдрийн хүртэлх хугацаанд дүүргийн хэмжээнд зохион байгуулж, шалгарсан иргэдийг 2023 оны 09 дүгээр сарын 16-наас 11 дүгээр сарын 25-ныг хүртэлх хугацаанд Нийслэлийн шигшээ тэмцээнд оролцуулсугай.
- 2. Арга хэмжээний зардалд 128,965,000 (Нэг зуун хорин найман сая есөн зуун жаран таван мянга)-н төгрөгийг захирамжийн дагуу нэмэлт санхүүжилтийн зардлаас гаргахыг нягтлан бодогч (П.Бат-Оюун)-д зөвшөөрсүгэй.
- 3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Биеийн тамирын хэлтсийн дарга (С.Сувд)-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ *Demid* Д.ОТГОНСҮРЭН

